



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 31 өдөр

Дугаар 90

Ховд

Г Эрүүл мэндийн талаар авах зарим Г
арга хэмжээний тухай

“Эрүүл мэндийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний тухай” аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Ц.Мягмарсүрэнгийн мэдээллийг хэлэлцээд хүн амын эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндэд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлүүдийг бууруулахад чиглэгдсэн “Эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах” хөтөлбөрт орон нутгийн хөгжлийн сангаас 100.0 сая, “Үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин” хөтөлбөрт Хөшөөт хөгжил сангаас 250.0 сая, “Эх хүүхдийн ээлтэй тусламж үйлчилгээ” хөтөлбөрт 185.0 сая төгрөг тус тус батлагдсанаас 2019 оны 3 дугаар улирлын байдлаар хөтөлбөрүүдийн санхүүжилтийн дундаж 54.8 хувьтай байна. Цаашид дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байгааг ТЭМДЭГЛЭЭД:

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 03 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Засаг дарга / Б.Дүгэржав/-д ҮҮРЭГ БОЛГОХ нь:

1.Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт эрүүл мэндийн чиглэлээр тусгагдсан зорилтуудыг хангах, Эрүүл мэндийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд сумдын Засаг дарга болон Өрхийн эрүүл мэндийн төвүүд, харьяа байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулан, оролцоог дээшлүүлж, удирдлага зохион байгуулалтаар хангах.

2.Эрүүл мэндийн дэд хөтөлбөрүүдэд аймаг орон нутгаас олгох санхүүжилтийн хэмжээг батлагдсан түвшинд хүргэж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

0000275

3.Эрүүл мэндийн байгууллагын боловсон хүчнийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах, тэнд ажиллагсдын ажиллах нөхцөл боломж, нийгмийн хангамжийг сайжруулах, сургалт семинарт хамруулах, мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх талаар дорвитой арга хэмжээ авч, бодит үр дүнд хүргэх.

4.Аймгийн хэмжээнд ажиллаж байгаа эмийн эргэлтийн сангуудын өмчлөл, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг оновчтой болгох бодлого боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралд танилцуулах.

Хоёр. Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Мягмарсүрэн/-д ДААЛГАХ нь:

1.Эрүүл мэндийн салбарын боловсон хүчнийг мэргэшүүлэх, чадавхжуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, орчин нөхцөлийг дээшлүүлэхэд салбарын бүх шатны төр, хувийн хэвшлийн байгууллагын удирдлагуудын оролцоог сайжруулан, мэргэшил арга зүйгээр хангаж ажиллах.

2.Үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц байдал, шалгуур үзүүлэлтэд улирал бүр үнэлгээ хийж зөвлөмж хүргүүлэх, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад тулгамдаж буй асуудлуудыг судалж шийдвэрлэх, эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүдийг сайжруулах бодлого боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх, өвчлөлийн эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг оношилгооны хүртээмж, чанарыг сайжруулах.

3.Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг эрүүл мэндийн салбарын байгууллагын санал, хүсэлт, судалгаанд тулгуурлан оновчтой, үр дүнтэй, шуурхай хэрэгжүүлэх талаар санаачилга өрнүүлэн ажиллах.

4.Баруун бүсийн Оношилгоо эмчилгээний төв болон сумдын Эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн салбар дундын ажлын уялдаа холбоог сайжруулж, иргэдэд хүргэх эрүүл мэндийн үйлчилгээг шинэ шатанд гаргаж өвчнийг эрт илрүүлэх, оношлох, иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй үйлчлэх нөхцөл боломжийг эрс сайжруулах.

5.Сумдын эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвүүд болон анхан шатны эмнэлгүүдэд шинээр төгссөн эмч, мэргэжилтнүүдийг ажиллууль, туршлагажуулах, чадавхжуулах, шат дараатай мэргэжил дээшлүүлэх боловсон хүчний бодлого гаргаж хэрэгжүүлэх.

6.Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дэргэдэх хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөл, багийн Иргэдийн нийтийн хурлын төлөөллийг оролцуулж, иргэдийн оролцоотой хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

Гурав. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 31 өдөр

Дугаар 91

Ховд

Аймгийн Нийтийн номын санг
Магсарын Баянзулын нэрэмжит
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12, Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2, 6.4 дахь заалтууд, аймгийн Засаг даргын саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Нийтийн номын санг Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, соён гэгээрүүлэгч, нэрт судлаач, ном зүйч, Ховд аймгийн Мянгад сумын харьяат Магсарын Баянзулын нэрэмжит болгосугай.

2. Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн Магсарын Баянзулын намтар, бүтээл туурвилыг иргэд, олон нийтэд өргөнөөр сурталчлан, нийтийн хүртээл болгож, алдар гавьяаг нь мөнхжүүлж, алдаршуулж ажиллахыг аймгийн Нийтийн номын сангийн эрхлэгч /Т.Эрдэнэтуяа/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ

0000268



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 31 өдөр

Дугаар 92

Ховд

Г Төрийн дээд шагналаар шагнуулахаар
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүрсүгэй. Үүнд:

“Монгол Улсын Хөдөлмөрийн баатар”-аар

1. Иманхан Төлөөгөн - Ховд аймгийн Буянт сум, Норжинхайран багийн иргэн, тариаланч

“Монгол Улсын Гавьяат хуульч”- аар

1. Төмөр Өнөр - Жаргалант сум, Жаргалан багийн иргэн, нотариатч

“Монгол Улсын Гавьяат хуульч”- аар

1. Дорж Тайванхүү - Жаргалант сум, Цамбагарав багийн иргэн

“Монгол Улсын Гавьяат эдийн засагч” - аар

1. Чойжав Бямбажав - Жаргалант сум, Наран багийн иргэн

“Монгол Улсын Хүний гавьяат эмч”- ээр

1. Цэрэндорж Даржаа - Ховд аймаг бүсийн оношилгоо эмчилгээний төв, “Ая заяа” эмнэлгийн зөвлөх эмч

0000275

“Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-гоор

1. Магсар Нямжав - Жаргалант сум, Алагтолгой багийн иргэн
2. Янпил Бал - Жаргалант сум, Бичигт багийн иргэн
3. Сэрээтэр Цэрмаа - Ховд аймгийн “Ахмад чөлөөт эмч нар”
төрийн бус байгуулагд мэдрэл сэтгэцийн эмч
4. Чой Рагчаа - Булган сум, Далт багийн өндөр настан
5. Содов Бааст - Булган сум, Далт багийн иргэн
6. Дамдин Гантулга - Ховд Их Сургуулийн дүрслэх урлаг,
дизайны багш
7. Базарсад Хүрэлбаатар - “Төгөлдөр” дуу дүрс бичлэгийн студийн
захирал

“Алтангадас одон”- гоор

1. Дамдинсүрэн Саруул - Ховд Их Сургуулийн багш
2. Цогтбаяр Цэрэнлхам - Жаргалант сумын II дугаар сургуулийн
захирал
3. Гончиг Алтанцэцэг - Жаргалант сумын Ерөнхий боловсролын III
дугаар сургуулийн багш
4. Чойдор Хорлоо - Үенч сум, Улиаст багийн өндөр настан
5. Батмөнх Батхуяг - Алтай сум, Бодонч багийн малчин
6. Дамдин Сундуй - Чандмань сум, Жаргалант багийн өндөр
настан
7. Очир Зулай - Чандмань сум, Жаргалант багийн өндөр
настан
8. Намхай Хашзандан - Чандмань сум, Жаргалант багийн өндөр
настан
9. Готов Баянцагаан - Жаргалант сум, Цамбагарав багийн өндөр
настан
10. Хамит Кулиза - Жаргалант сум, Наран багийн иргэн
11. Базарваань Цэрэндолгор - Эрдэнэбүрэн сумын Ерөнхий боловсролын
сургуулийн багш
12. Цэдэн-Иш Баттогтох - Эрдэнэбүрэн сум, Хар-Ус багийн иргэн

“Хөдөлмөрийн хүндэт медаль”- аар

1. Нацагдорж Ням-Осор - Манхан сум, Бичигт багийн иргэн
2. Шарав Дорждэрэм - Ховд нефть худалдааны салбарын ахлан
нягтлан бодогч

- | | |
|-------------------------------|--|
| 3. Туулай Батнасан | - НИК ХХК-ийн шатахуун тээврийн жолооч |
| 4. Таквай Мархаба | - Ховд сум, Баянбулаг багийн малчин |
| 5. Халтай Батнасан | - Манхан сум, Баянгол багийн малчин |
| 6. Хайсандаа Баасанхалтар | - Манхан сум, Баянгол багийн малчин |
| 7. Будшир Нямхүү | - Жаргалант сум, Цамбагарав багийн иргэн |
| 8. Янжив Насантогтох | - Эрдэнэбүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн багш |
| 9. Пунцагдаш Өлгийчимэг | - Эрдэнэбүрэн сум, Хар-Ус багийн иргэн |
| 10. Батаа Дашзэвэг | - “Хаш-Өргөө” ХХК –ийн инженер |
| 11. Банзрагч Анхбаяр | - Ховд аймгийн Боловсрол, Соёл урлагийн газрын мэргэжилтэн |
| 12. Эрдэнээ Бат-Эрдэнэ | - Ховд аймгийн Боловсрол, Соёл урлагийн газрын мэргэжилтэн |
| 13. Минап Бердигүл | - Ховд аймгийн Боловсрол, Соёл урлагийн газрын мэргэжилтэн |
| 14. Соном Оюундэлгэр | - Ховд аймгийн Боловсрол, урлагийн газрын мэргэжилтэн |
| 15. Батаа Алтантуяа | - Ховд Их Сургуулийн Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургуулийн багш |
| 16. Цэрэндорж Гэрэлчимэг | - Ховд Их Сургуулийн үйлчлэгч |
| 17. Очир Жаахлай
настан | - Жаргалант сум, Бичигт багийн өндөр |
| 18. Санж Отгон | - Жаргалант сум, Баатархайрхан багийн өндөр настан |
| 19. Гөлгөн Алтангэрэл
багш | - Жаргалант сумын III дугаар сургуулийн |
| 20. Цэвээнжав Ичинхорлоо | - Ховд Их Сургуулийн багш |
| 21. Цэенхорлоо Баянбилэг | - Жаргалант сумын II дугаар сургуулийн архив бичиг хэргийн ажилтан |
| 22. Баатар Туул
багш | - Жаргалант сумын III дугаар сургуулийн |
| 23. Дашвандан Жавхлантунгалаг | - Жаргалант сумын III дугаар цэцэрлэгийн багш |
| 24. Баттулга Оюунчимэг | - Жаргалант сумын III дугаар цэцэрлэгийн багш |
| 25. Тогтох Эрдэнэ-Оюун | - Жаргалант сумын III дугаар цэцэрлэгийн багш |
| 26. Жамба Дарьсүрэн | - Жаргалант сумын III дугаар цэцэрлэгийн |

туслах багш

27. Баасанхүү Өлзийбадрах - Ховд АЗЗА ТӨХК-ний хөдөлмөр аюулгүй
байдлын инженер
28. Цэрэндорж Мөнхнаран - Ховд АЗЗА ТӨХК-ний ерөнхий нягтлан
бодогч
29. Цэрэндорж Мягмардорж - Ховд АЗЗА ТӨХК-ний жолооч
30. Дагвадорж Түвшинсайхан - Ховд АЗЗА ТӨХК-ний жолооч
31. Бямбаа Бямбадорж - Ховд АЗЗА ТӨХК-ний жолооч
32. Батаа Ганхүү - Зэрэг сум, Бургасан багийн малчин
33. Бейсен Хуантхан - Ховд сумын Хаан банкны эрхлэгч
34. Шагдар Баатаржав - ЗДТГ-ын манаач



ХУРЛЫН ДАРГА

Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 31 өдөр

Дугаар 93

Ховд

Хөрөнгө шилжүүлэх зөвшөөрөл
олгох тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, 80 дугаар зүйл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.2, 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумдын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 106 нэр төрлийн нийт 438809474 төгрөг /дөрвөн зуун гучин найман сая найман зуун есөн мянга дөрвөн зуун далан дөрөв/-ийн балансын үнэтэй, 300233109 төгрөг /гурван зуун сая хоёр зуун гучин гурван мянга нэг зуун ес/-ийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг аймгийн Мал эмнэлгийн газарт балансаас, балансад шилжүүлсүгэй.

2. Хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх ажлыг зохион байгуулахыг сумдын ЗДТГ-ын дарга нарт, болон аймгийн Мал эмнэлгийн газрын дарга /Д.Батцэнгэл/-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



СУМДЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРААС АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛЭГИЙН ГАЗАРТ ШИЛЖҮҮЛЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ


дд	Сумын нэр	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Ашиглалта нд орсон он	Балансын үнэ	Хуримтлагдс ан элэгдэл	Үлдэх өртөг	Нийт үнэ
1	Алтай	Автомашин	ш	1	2011	19,990,000	19,990,000	-	19,990,000
2		Мотоцикл	ш	1	2017	2,500,000	1,250,000	1,250,000	2,500,000
3		Вакцины хөргүүр	ш	1	2012	369,400	369,400	-	369,400
4		Зөөврийн ванн	ш	1	2018	5,100,000	1,275,000	3,825,000	5,100,000
5		Төмөр шүүгээ	ш	1	2010	350,000	350,000	-	350,000
Алтай сумын нийт дүн						28,309,400	23,234,400	5,075,000	28,309,400
1	Булган	Автомашин	ш	1	2011	19,990,000	19,990,000	-	19,990,000
2		Мотоцикл	ш	1	2017	2,500,000	1,250,000	1,250,000	2,500,000
3		Зөөврийн хашаа	ш	1	2018	4,896,250	1,224,062	3,672,188	4,896,250
4		Зөөврийн ванн	ш	1	2018	5,100,000	1,275,000	3,825,000	5,100,000
5		GPS	ш	1	2010	90,000	90,000	-	90,000
6		Ширээ	ш	1	2010	80,000	80,000	-	80,000
Булган сумын нийт дүн						32,656,250	23,909,062	8,747,188	28,309,400
1	Буянт	Автомашин	ш	1	2011	19,990,000	19,990,000	-	19,990,000
2		Мотоцикл	ш	1	2017	2,500,000	1,250,000	1,250,000	2,500,000
3		Суурин компьютер	ш	1	2012	385,000	385,000	-	385,000
4		Сандал	ш	1	2012	29,150	29,150	-	29,150
5		Принтер	ш	1	2010	300,000	300,000	-	300,000
6		Ширээ	ш	1	2010	266,000	266,000	-	266,000
Буянт сумын нийт дүн						23,470,150	22,220,150	1,250,000	23,470,150
1	Дарви	Төмөр шүүгээ	ш	1	2012	140,000	140,000	-	140,000
2		Мотоцикл	ш	1	2017	2,500,000	1,250,000	1,250,000	2,500,000
3		Принтер	ш	1	2011	179,999	179,999	-	179,999
4		Зөөврийн ванн	ш	1	2018	5,100,000	1,275,000	3,825,000	5,100,000

5		Вакцины хөргүүр	ш	1	2012	369,400	369,400	-	369,400
Дарви сумын нийт дүн						8,289,399	3,214,399	5,075,000	8,289,399
1	Дуут	Компьютер	ш	1	2018	1,100,000	220,000	880,000	1,100,000
2		Мотоцикл	ш	1	2017	2,500,000	1,250,000	1,250,000	2,500,000
3		Өнгөт принтер	ш	1	2018	386,667	77,333	309,333	386,667
4		Яаралтай тусламжийн багц	ш	1	2018	732,000	183,000	549,000	732,000
5		Мал угаалгын мотопомп	ш	1	2018	1,280,000	320,000	960,000	1,280,000
6		Халдваргүйтгэл, шимэгчгүйтэлийн бэлдмэийн	ш	1	2018	310,000	77,500	232,500	310,000
7		Зөөврийн хэвлэгч	ш	1	2018	240,000	60,000	180,000	240,000
8		Малын ээмэгний мэдээлэл уншигч төхөөрөмж	ш	1	2018	1,620,000	405,000	1,215,000	1,620,000
9		Ээмэглэгч бахь	ш	1	2018	15,000	3,750	11,250	15,000
10		Премитест	ш	1	2018	2,400,000	600,000	1,800,000	2,400,000
Дуут сумын нийт дүн						10,583,667	3,196,583	7,387,083	10,583,667
1	Дөргөн	Мотоцикл	ш	1	2017	2,500,000	1,250,000	1,250,000	2,500,000
2		Суурин компьютер	ш	1	2012	960,000	960,000	-	960,000
3		Принтер	ш	1	2011	340,000	340,000	-	340,000
4		Зөөврийн хашаа	ш	1	2018	4,896,250	1,224,062	3,672,188	4,896,250
5		Зөөврийн ванн	ш	1	2018	5,100,000	1,275,000	3,825,000	5,100,000
6		Төмөр шүүгээ	ш	1	2011	115,000	115,000	-	115,000
Дөргөн сумын нийт дүн						13,911,250	5,164,062	8,747,188	13,911,250
1	Зэрэг	Төмөр сейф	ш	1	1983	55,084	55,084	-	55,084
2		Мотоцикл	ш	1	2017	2,500,000	1,250,000	1,250,000	2,500,000
3		Ширээ	ш	1	2005	446,700	446,700	-	446,700
4		Вакцины хөргүүр	ш	1	2012	369,400	369,400	-	369,400
Зэрэг сумын нийт дүн						3,371,184	2,121,184	1,250,000	3,371,184
1	Манхан	Төмөр шүүгээ	ш	1	2010	86,600	86,600	-	86,600
2		Мотоцикл	ш	1	2017	2,500,000	1,250,000	1,250,000	2,500,000
3		Ширээ	ш	1	2011	167,950	167,950	-	167,950
4		GPS	ш	1	2011	450,000	450,000	-	450,000
5		Зөөврийн хашаа	ш	1	2018	4,896,250	1,224,062	3,672,188	4,896,250
Манхан сумын нийт дүн						8,100,800	3,178,612	4,922,188	8,100,800
1	Мөст	Автомашин	ш	1	2011	19,990,000	19,990,000	-	19,990,000
2		Мотоцикл	ш	1	2017	2,500,000	1,250,000	1,250,000	2,500,000
3		Төмөр сейф	ш	1	1994	161,200	161,200	-	161,200
4		Барилга	ш	1	1985	116,532,800	66,035,253	50,497,547	116,532,800
5		Саарал сейф	ш	1	2010	100,000	100,000	-	100,000
Мөст сумын нийт дүн						139,284,000	87,536,453	51,747,547	139,284,000

1	Мөнххайрхан	Автомашин	ш	1	2012	19,990,000	19,990,000	-	19,990,000
2		Мотоцикл	ш	1	2017	2,500,000	1,250,000	1,250,000	2,500,000
3		Компьютер	ш	1	2018	1,100,000	220,000	880,000	1,100,000
4		Өнгөт принтер	ш	1	2018	386,667	77,333	309,333	386,667
5		Төмөр шүүгээ	ш	1	2011	123,000	123,000	-	123,000
6		Зөөврийн ванн	ш	1	2018	5,100,000	1,275,000	3,825,000	5,100,000
7		Зөөврийн хашаа	ш	1	2018	4,896,250	1,224,062	3,672,188	4,896,250
8		Премитест	ш	1	2018	2,400,000	600,000	1,800,000	2,400,000
9		Ээмэглэгч бахь	ш	1	2018	15,000	3,750	11,250	15,000
10		Зөөврийн хэвлэгч	ш	1	2018	240,000	60,000	180,000	240,000
11		Малын ээмэгний мэдээлэл уншигч төхөөрөмж	ш	1	2018	1,620,000	405,000	1,215,000	1,620,000
12		Халдваргүйтгэл, шимэгчгүйтэлийн бэлдмэийн	ш	1	2018	310,000	77,500	232,500	310,000
13		Яаралтай тусламжийн багц	ш	1	2018	732,000	183,000	549,000	732,000
14		Мал угаалгын мотопомп	ш	1	2018	1,280,000	320,000	960,000	1,280,000
Мөнххайрхан сумын нийт дүн						40,692,917	25,808,645	14,884,271	40,692,917
1	Мянгад	Автомашин	ш	1	2011	19,990,000	19,990,000	-	19,990,000
2		Мотоцикл	ш	1	2017	2,500,000	1,250,000	1,250,000	2,500,000
3		Суурин компьютер	ш	1	2011	640,000	640,000	-	640,000
4		Принтер	ш	1	2011	180,000	180,000	-	180,000
5		Ширээ	ш	1	2010	130,000	130,000	-	130,000
6		Сандал	ш	1	2010	20,000	20,000	-	20,000
7		Төмөр шүүгээ	ш	1	2011	190,000	190,000	-	190,000
8		GPS	ш	1	2011	430,000	430,000	-	430,000
9		Вакцины хөргүүр	ш	1	2012	369,400	369,400	-	369,400
Мянгад сумын нийт дүн						24,449,400	23,199,400	1,250,000	24,449,400
1	Үенч	Суурин компьютер	ш	1	2010	639,999	639,999	-	639,999
2		Ширээ	ш	1	2010	167,950	167,950	-	167,950
3		Төмөр шүүгээ	ш	1	2010	19,000	19,000	-	19,000
4		Автомашин	ш	1	2010	19,990,000	19,990,000	-	19,990,000
5		Мотоцикл	ш	1	2017	2,500,000	1,250,000	1,250,000	2,500,000
6		Принтер	ш	1	2010	179,999	179,999	-	179,999
7		Сандал	ш	1	2010	29,146	29,146	-	29,146
8		Зөөврийн ванн	ш	1	2018	5,100,000	1,275,000	3,825,000	5,100,000
Үенч сумын нийт дүн						28,626,094	23,551,094	5,075,000	28,626,094
1	Ховд	Проектор	ш	1	2010	669,000	669,000	-	669,000
2		Мотоцикл	ш	1	2017	2,500,000	1,250,000	1,250,000	2,500,000
3		Зөөврийн ванн	ш	1	2018	5,100,000	1,275,000	3,825,000	5,100,000

4		Зөөврийн хашаа	ш	1	2018	4,896,250	1,224,062	3,672,188	4,896,250
Ховд сумын нийт дүн						13,165,250	4,418,062	8,747,188	13,165,250
1	Цэцэг	Автомашин	ш	1	2011	19,990,000	19,990,000	-	19,990,000
2		Мотоцикл	ш	1	2017	2,500,000	1,250,000	1,250,000	2,500,000
3		Ширээ	ш	1	2010	135,000	135,000	-	135,000
4		Төмөр шүүгээ	ш	1	2011	152,000	152,000	-	152,000
5		Вакцины хөргүүр	ш	1	2012	369,400	369,400	-	369,400
Цэцэг сумын нийт дүн						23,146,400	21,896,400	1,250,000	23,146,400
1	Чандмань	Автомашин	ш	1	2011	19,990,000	19,990,000	-	19,990,000
2		Мотоцикл	ш	1	2017	2,500,000	1,250,000	1,250,000	2,500,000
3		Мал угаалгын мотопомп	ш	2	2016	50,000	50,000	-	50,000
4		Өнгөт принтер	ш	1	2018	386,667	77,333	309,333	386,667
5		Зөөврийн хашаа	ш	1	2018	4,896,250	1,224,062	3,672,188	4,896,250
6		Премитест	ш	1	2018	2,400,000	600,000	1,800,000	2,400,000
7		Суурин компьютер	ш	1	2012	639,999	639,999	-	639,999
8		Малын ээмэгний мэдээлэл уншигч төхөөрөмж	ш	1	2018	1,620,000	405,000	1,215,000	1,620,000
Чандмань сумын нийт дүн						32,482,916	24,236,394	8,246,521	32,482,916
1	Эрдэнэбүрэн	Суурин компьютер	ш	1	2012	640,000	640,000	-	640,000
2		Принтер	ш	1	2011	180,000	180,000	-	180,000
3		Сандал	ш	1	2012	29,147	29,147	-	29,147
4		Мотоцикл	ш	1	2017	2,500,000	1,250,000	1,250,000	2,500,000
5		Зөөврийн хашаа	ш	1	2018	4,896,250	1,224,062	3,672,188	4,896,250
6		Мал угаалгын мотопомп	ш	1	2016	25,000	25,000	-	25,000
Эрдэнэбүрэн сумын нийт дүн						8,270,397	3,348,209	4,922,188	8,270,397
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН						438,809,474	300,233,109	138,576,362	426,173,225

oooOooo



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 11 сарын 12 өдөр

Дугаар 94

Ховд

Хуралдаан зарлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.1.1-ийн “д”, 18.1.2-ын “б”, “з”, 20 дугаар зүйлийн 20.1.1, 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтууд, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 10 дугаар хуралдааныг 2019 оны 12 дугаар сарын 2,3-ний өдрүүдэд Ховд хотод, аймгийн Нутгийн удирдлагын ордонд хуралдуулж, дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:

1.1. Төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай

Илтгэгч нь: Аймгийн Сонгуулийн хорооны дарга
Л.Батбаяр

1.2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны үйл ажиллагааны тайлан, цаашдын зорилтын тухай

Илтгэгч нь: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын дарга Г.Пүрэвганди

1.3. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав

1.4. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийн тухай

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав

1.5. Аймгийн 2018 оны төсвийн гүйцэтгэл, 2019 оны батлагдсан төсвийн хэрэгжилт, 2020 оны төсвийн төслийн тухай

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав

0000280

1.6.Аймгийн 2020 оны төсвийн төсөлд болон төсвийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх талаар аймгийн Аудитын газраас өгөх саналын тухай

Илтгэгч нь: Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Х.Болдбаатар


1.7.Аймгийн газар зохион байгуулалтын 2019 оны төлөвлөгөөний биелэлт,
2020 оны төлөвлөгөөний төслийн тухай

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав

1.8.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны “Мал эмнэлгийн ажил үйлчилгээ, шинжилгээний хөлсний норматив тогтоох тухай” 8/10 дугаар тогтоол, “Ховд аймгийн орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж сэтлэх, нөхөн сэргээх ажлын зөвшөөрөл олгох, гүйцэтгэх журам батлах тухай” 8/08 дугаар тогтоолуудыг хүчингүй болгох тухай

2.Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг нийтэд мэдээлж, хуралдааны бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ПҮРЭВГАНДИ